



“Дөргөний УЦС” төслийн “Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт хангалтгүй байна

Дөргөний УЦС-ын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон нийгэм-эдийн засаг, байгаль орчин, хууль эрх зүйн холбогдол бүхий олон асуудлууд хөндөгдөж 2005 онд Байгаль орчинд нөлөөллөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийгдсэнээр төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд удахгүй ашиглалтанд орох дөхөж байна.

Төслийн Байгаль орчинд нөлөөллөх байдлын нарийвчилсан үнэлгээний үр дүнд байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах зөвлөмж боловсруулан, улмаар “Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө” боловсруулан тодорхой ажлуудыг тодорхой цаг хугацаанд тодорхой хариуцах эзэнтэй зааж өгсөн. Гэвч, өнөөгийн байдлаар эдгээр зөвлөмж болон менежментийн төлөвлөгөөнд заагдсан ажлуудаас хэрэгжиж байгаа нь цөөн, зарим ажлууд нь огт хэрэгжиж эхлээгүй, хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэргүй байсаар байна.

Тиймээс, энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх үүднээс 2007 оны 2-р сарын 7-ны өдөр Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон Монголын дархалсан газар нутгийн нийгэмлэг хамтран Дөргөний УЦС-ын асуудалтай холбогдол бүхий байгууллагуудын төлөөлөлийг урин уулзалт ярилцлага зохион байгууллаа. Уулзалтанд зохион байгуулагчдаас гадна БОЯ, ТЭХЯ, СЭЗЯ, УМХГ, “Алтан-Эко” үнэлгээний компани, Ус цаг уурын хүрээлэнгийн усны сектор, “Дөргөний УЦС” төслийн хэрэгжүүлэгч нэгж зэрэг байгууллагын төлөөлөл, мэргэжилтэн нар оролцлоо.

Ярилцлагын үр дүнд “Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө”-нд заагдсан ажлуудын хэрэгжилт хангалтгүй байгааг тэмдэглээд, үүнд шаардлагатай байгаа 80 гаруй сая төгрөгийг гаргах санхүүгийн эх үүсвэр одоо болтол тодорхойгүй байгааг онцолж энэ асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг төсөл хэрэгжүүлэгчдэд зөвлөллөө.

Нэмэлт мэдээллийг энэ хаягаар авч болно. E-mail: batnasan@wwf.mn Утас: 311659